НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

## 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 09 Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Суурь түвшин | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хүрэх түвшин үр дүн | Хөрөнгийн эх үүсвэр, зарцуулах мөнгөн дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилго 1: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | |
| 1 | 1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк. твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх; | Жилдээ | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео график, нийтлэл, хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк)-түгээсэн. Үүнд:<br>-Ном, гарын авлага-9<br>-Хэвлэмэл материал сурталчилгаа-12<br>-Видео мэдээ-8<br>-Сургалтын материал-2<br>Байгууллагын цахим хуудсанд байршуулсан видео мэдээг давхардсан тоогоор 283 удаа, цахим ном гарын гарын авлага зэргийг давхардсан тоогоор 79 удаа үзсэн байна. Тус газрын албан ёсны олон нийтийн сүлжээний фэйсбүүк хуудсаар түгээсэн шторк, инфографик, зурагт | Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх. | Авлигын эсрэг мэдээллийг иргэд олон нийтэд ил тод мэдээлсэн байна. | - | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео график, нийтлэл, хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк)-түгээсэн. Үүнд:<br>Ном, гарын авлага-1<br>2022-05-09-"Авлигын эсрэг үндэсний чуулган-2021" илтгэлүүдийн эмхэтгэл,<br>-Хэвлэмэл материал сурталчилгаа-1<br>2022-03-15-Авлигатай тэмцэх үйл ажиллагаа дэлхий дахинд<br>-Видео мэдээ-13<br>1. 2022-01-04-Эдийн засагч Н.Энхбаяр: Авлигын талаарх хандлагаа өөрчлөх ёстой,<br>2. 2022-01-21 - "Авлигын эсрэг үндэсний чуулган-2021" арга хэмжээнээс бэлтгэсэн нэвтрүүлэг,<br>3. 2022-01-19-Хөрөнгө, орлогоо мэдүүлэх заавар Нийтийн албан тушаалтан Та 2022 оны 2 дугаар сарын 15-ны дотор ХАСХОМ-ээ шинэчлэн бүртгүүлнэ үү,<br>4. 2022-02-08-Д.Дагиймаа: Хүүхдэд багаас нь зөв зүйлийг таниулах ёстой,<br>5. 2022-02-14-"Хуулийн засаглал": авлига, албан тушаалын гэмт хэрэгт |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуудас 459 удаа үзсэн байна.<br>Нийт 821. | | | | хуулийн хатуу хариуцлага тооцдог, ялын бодлогыг чангатгах цаг болсон<br>6. 2022-03-03-Том толгойт цахим хичээл,<br>7. 2022-05-16-Найруулагч У.Пүрэвжав: Ирээдүйг хамгаалах, хайрлах хамгийн зөв арга бол авлигыг тэвчих,<br>8. 2022-01-05, 2022-02-10, 2022-02-25, 2022-03-09, 2022-03-23, 2022-05-06-ны өдрүүдийн -Авлигатай тэмцэх газрын мэдээлэл нэвтрүүлэг,<br>9. АТГ- 10.26- "Найзын яриа-Жижигхэн хэрнээ үл ялиг шалтгаанаар шударга ёс сэргэн манддаг" сэдэвт өөрчлөлтийг хамтдаа аянд нэгдэж байна.<br>10. Авлигыг мэдээлэх утас-110<br>11. Төрийн байгууллагын албан тушаалтнуудад авлигын тухай цахим сургалт зохион байгуулав<br>12. "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн баримтуудад хяналт шалгалт хийв"<br>-Сургалтын материал, уралдаан тэмцээн, подкаст нэвтрүүлэг, радио контент хэсэгт тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газрын цахим хуудаст сургалтын материалын шинээр ороогүй болно.<br>Байгууллагын цахим хуудасд байршуулсан видео мэдээг давхардсан тоогоор 466 удаа, цахим ном гарын гарын авлага зэргийг давхардсан тоогоор 146 удаа үзсэн байна. Тус газрын албан ёсны олон нийтийн сүлжээний фэйсбүүк хуудсаар түгээсэн шторк, инфографик, зурагт хуудас 654 удаа үзсэн байна. |
| 2 | 1.2.Авлигатай | Жилдээ | Авлигатай тэмцэх | -Дэмжиж | Авлигатай | - | НЗДТГ-ын 2022 оны 02 дугаар сарын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах; | | газраас Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр олон нийтийн санаа бодлыг сонсох, санал, санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааны ололт амжилт, хүндрэл бэрхшээлийг дүгнэн хэлэлцэх зорилгоор зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган-2021”-д газрын нийт албан хаагчид 100 хувь идэвхтэй хамрагдсан. | хамтран ажилласан байх<br>-Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх. | тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж хамтран ажилласан байна. | | 24-ний өдрийн 03/798 дугаар албан бичгээр ирүүлсэн “Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогч, илтгэгчдээс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Монголын хүүхдийн ордонд зохион байгуулагдсан “Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөн”-д тус газрын дарга, орлогч дарга, 5 нэгжийн дарга оролцсон.<br>Авлигатай тэмцэх газрын 2022 оны 03 дугар сарын 18-ны өдрийн 01/3817 дугаар албан бичгээр ирүүлсэн “Хамтран ажиллах тухай” зөвлөмжийн хэрэгжилтийг ханган газрын 30 албан хаагч Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын цахим хуудсанд нэгдэж, мэдээ, мэдээллийг тухай бүр олон нийтэд түгээн ажиллаж байна.<br>“Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд гарсан мэдээлэл, сурталчилгааны материалыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсаар дамжуулан нийт албан хаагчид тухай бүр түгээж ажилласан.<br>2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Тус газраас санаачлан Монгол Улсын Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Худалдан авах ажиллагаанд авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | асуудлын талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 10 агентлаг, орон нутгийн өмчит 19 байгууллага, нийслэлийн 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны нийт 180 гаруй албан хаагчийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.<br>Тус сургалтаар:<br>1.Худалдан авах ажиллагаанд өрсөлдөөнийг хэрхэн зохицуулах түүний үр дүнгийн тухай, Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын Ахлах мэргэжилтэн С.Гэрэлцэцэг,<br>2.Худалдан авах ажиллагаанд авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудал сэдвээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар У.Номин-Эрдэнэ,<br>3.Цахим худалдан авах ажиллагааны тухай Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Цэрэнсамбуу,<br>4.Худалдан авах ажиллагааны тайлан мэдээний нэгдсэн явцын мэдээний тухай танилцуулгыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Б.Түмэнжаргал,<br>5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар Сангийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | яамны Хууль эрхзүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ц.Батзул нар танилцуулга мэдээлэл өгсөн.<br>НЗДТГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 03/5899 дүгээр албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Байгууллагын цахим хуудасны эхний нүүр хэсэгт Авлигатай тэмцэх газрын “110” тусгай дугаарын утсыг сурталчилсан постер байршуулж, нийт албан хаагчид нэгдэн шинээр орж буй мэдээ мэдээллийг тухай бүр нийтлэн ажиллаж байна. |
| 3 | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах; | Жилдээ | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах зорилгоор “Шударга ёс, хөгжилд дэвшилд 110” мэдээллийг самбарыг 520,000 төгрөгөөр хийлгүүлсэн бөгөөд мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. | -Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх<br>-Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх. | Байгууллагад мэдээллийн самбар байршуулсан байна. | - | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах зорилгоор “Шударга ёс, хөгжилд дэвшилд 110” мэдээллийг самбарыг хийлгүүлсэн бөгөөд мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.<br>Нотлох баримтыг хавсралтаар хүргүүлэв. |
| Зорилго 2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ- аас зохион байгуулах сургалтад хамруулах | | | | | | | |
| 4 | 2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ- т хүргүүлсэн байх; | 1 дүгээр сард | 2021 оны 1 дүгээр сард НЗДТГ-т сургалтад хамрагдах 20 албан хаагчийн жагсаалтыг хүргүүлсэн. | Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх. | Төлөвлөгөөнд санал хүргүүлсэн байна. | - | Тус газрын МТХ-ээс Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 10-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн. |
| 5 | 2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын | Тухай бүр | 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр | Сургалтад хамрагдсан | Албан хаагчдыг | - | Өнөөдрийн байдлаар АТГ-аас зохион байгуулсан авлигын эсрэг анхан |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулсан байх; | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан. Авлигын эсрэг хуульд заасан төрийн байгууллагын хэрэгжүүлэх нийтлэг үүргийн хүрээнд хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах талаар "Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад зориулсан сургалт"-д 10 албан хаагч, | албан хаагчийн тоо. | сургалтад хамруулсан байна. | | шатны сургалтад албан хаагчдаа хамруулаагүй байгаа бөгөөд сургалт зохион байгуулсан даруйд албан хаагчдаа хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Байгууллагын удирдлагын санаачилгаар Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх давтан сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр АТГ-тай хамтран зохион байгуулсан.<br>Сургалтаар Авлигатай тэмцэх газрын Комиссар Б.Сүрэнжав "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", Комиссар Д.Золжаргал "Авлигын гэмт хэргийн хуульчилагдсан байдал" сэдвээр тус тус зохион байгуулж, газрын 33 албан хаагч хамрагдлаа.<br>Албан хаагчдад сургалтын үеэр 5 ном, 11 төрлийн гарын авлагаар хангаж ажилласан.<br>2022 оны 01 дүгээр сарын 12, 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрүүдэд ЭБАТ С.Оюунцэцэг ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй албан хаагчдад ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах зүйлс сэдвээр сургалт зохион байгуулж, Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилан таниулсан. Мөн ЭБАТ-ын зүгээс шинээр томилогдсон албан хаагчдад тухай бүр авлигын эсрэг сургалтыг зохион байгуулан, мэдлэг мэдээллээр хангаж ажиллаж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2.3.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх; | Тухай бүр | 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Төрийн байгууллага болон төрийн албан хаагч нарт авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, авлигаас нийгэмд учруулах хор аюулыг ухуулан сурталчлах" цахим сургалтад тус газрын 16 албан хаагч; 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигийн гэмт хэргийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчныг хэрэгжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, таслан зогсооход чиглэсэн чадавхийг нэмэгдүүлэх" сэдэвт Хуулийн асуудал хариуцсан албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг давтан сургалтад тус газрын хуулийн хэлтсийн 2 | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо. | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байна. | - | Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх давтан сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр АТГ-тай хамтран зохион байгуулсан. Сургалтаар Авлигатай тэмцэх газрын Комиссар Б.Сүрэнжав "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", Комиссар Д.Золжаргал "Авлигын гэмт хэргийн хуульчилагдсан байдал" сэдвээр тус тус зохион байгуулж, газрын 33 албан хаагч хамрагдлаа.<br>Албан хаагчдад сургалтын үеэр 5 ном, 11 төрлийн гарын авлагаар хангаж ажилласан.<br>2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Тус газраас санаачлан Монгол Улсын Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Худалдан авах ажиллагаанд авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлын талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 10 агентлаг, орон нутгийн өмчит 19 байгууллага, нийслэлийн 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны нийт 180 гаруй албан хаагчийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан.<br>2021 оны ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй 10 албан хаагчийн нэрсийн жагсаалтыг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжилтэн тус тус хамруулсан. | | | | НЗДТГ-ын ЭБАТ Ө.Бат-Оргил албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлж, албан хаагчдад мэдүүлгийг хэрхэн бөглөх, мэдүүлэх талаар 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр сургалт хийж, арга зүйн зөвлөмж өгсөн.<br>Мэргэжилтнүүд ХАСХОМ мэдүүлэх болсонтой холбогдуулан 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр ЭБАТ С.Оюунцэцэг ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй албан хаагчдад ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах зүйлс сэдвээр сургалт зохион байгуулж, Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилан таниулсан. |
| 7 | 2.4.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх; | Жилдээ | Бүлтээхэй, дэлдээхэй хоёрын шударга тоглоом хүүхэлдэйн жүжгийг байгууллагын цахим хуудас болон Чингэлтэй дүүргийн 33 дугаар цэцэрлэгийн нэгдсэн групп, Баянзүрх дүүргийн 133 дугаар сургуулийн 4е ангийн группт түгээн ажилласан. | Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх,<br>-Хамрагдсан хүүхэд залуус, иргэд тоо. | Иргэд олон нийтийг мэдээллээр хангаж, үр дүнг тайлагнасан байна. | - | Авлигатай тэмцэх газар, болон Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төвийн цахим хуудаст нийт албан хаагчид нэгдэж, мэдээ мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудас болон албан хаагчдын фэйсбүүк хаягаар түгээн иргэд, олон нийтэд түгээн ажилласан. |
| Зорилго 3: Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх | | | | | | | |
| 8 | 3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх. | Тухай бүр | Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас зөвлөмж ирээгүй болно. | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх. | Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна. | - | НЗДТГ-ын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 03/798 дугаар албан бичгээр ирүүлсэн "Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцогч, илтгэгчдээс гаргасан зөвлөмжийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. |
| 9 | 3.2 Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Тухай бүр | Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас Мөрдөгчийн мэдэгдэл ирээгүй болно. | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх. | Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээ бүрэн биелсэн байна. | - | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу АТГ-аас ирүүлсэн 63 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг тус газрын өртгөтгөсөн хурлаар нийт албан хаагчдад танилцуулан, 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр АТГ-тай хамтран сургалт зохион байгуулж газрын 33 албан хаагч хамрагдсан. Сургалтаар алба хаагчдад 5 ном, 11 төрлийн гарын авлагаар хангасныг тараан өгч судлуулж байна.<br>Мөрдөгчийн мэдэгдлийн хариуг 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 4/1230 дугаар албан бичгээр 7 хуудас хавсралт бичгийн хамт АТГ-т хүргүүлсэн. |
| 10 | 3.3.Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Тухай бүр | Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулах албан бичиг ирээгүй болно. | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх. | Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээний биелэлт хангагдсан байна. | - | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 15 асуулт бүхий тест боловсруулж, 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр шалгалт авч дүнг нэгтгэсэн. Шалгалтад нийт 31 албан хаагч оролцохоос 30 алба хаагч оролцлоо. Нийт алба хаагчдаас Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлтэй хувийн харилцаа тогтоохгүй байх, тэдгээрээс хувийн болон албаны чиглэлээр тусламж дэмжлэг хүсэхгүй байх, мөн үнэлгээний хороонд ажиллах хугацаанд эдийн болон эдийн бус эд хөрөнгө, тэдгээрийн өмчлөх эрхийг шилжүүлэх, төлбөргүй эсхүл |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэхийг санал болгосон тохиолдолд энэ талаар хуульд заасны дагуу шууд удирдах албан тушаалтан болон Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэж ажиллах талаар мэдээлэл өгч, авлига, ашиг хонжоо, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, хандив, бэлэг авахгүй байх, хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлэн ажиллах талаар бичгээр баталгаа (2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр 32 албан хаагчаас, 6 сараас хойш томилогдсон 13 албан хаагчаас томилогдсон даруйд) авч ажилласан. |
| Зорилго 4: Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | | | | |
| 11 | 4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал; | Тухай бүр | Бүлтээхэй, дэлдээхэй хоёрын шударга тоглоом хүүхэлдэйн жүжгийг байгууллагын цахим хуудас болон Чингэлтэй дүүргийн 33 дугаар цэцэрлэгийн нэгдсэн групп, Баянзүрх дүүргийн 133 дугаар сургуулийн 4е ангийн группт түгээн ажилласан.<br>Авлигын эсрэг Үндэсний чуулганд нийт албан хаагчид идэвхтэй хамрагдсан. | Санал, санаачилга уриа, аянд нэгдэж, тодорхой үр дүнд хүрсэн байх. | Албан хаагчид болон иргэдийн авлигын талаарх мэдлэг дээшилсэн байна. | - | 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Монголын хүүхдийн ордонд зохион байгуулагдсан "Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөн"-д тус газрын дарга, орлогч дарга, 5 нэгжийн дарга оролцсон.<br>"Зөв зөвд шударга зөв" аяны хүрээнд гарсан мэдээлэл, сурталчилгааны материалыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсаар дамжуулан нийт албан хаагчид түгээж ажилласан<br>Газрын удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Авлигатай тэмцэх газар, болон Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төвийн цахим хуудаст нийт албан хаагчид нэгдэж, мэдээ мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудас болон албан хаагчдын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | фэйсбүүк хаягаар түгээн иргэд, олон нийтэд түгээн ажилласан.<br><br>Авлигатай тэмцэх газраас 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Барилгын салбар дахь авлигын эрсдэл ба инженерийн ёс зүй” сэдэвт хэлэлцүүлэгт НХААГ-ын дарга Г.Энхтайван панелистээр оролцож, оролцогчдын сонирхсон асуултад хариулж, мэдээ, мэдээллээр ханган ажилласан.<br>Цаашид тухай бүр Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга уриа аянд нэгдэж дэмжих ажиллах болно. |
| 12 | 4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | Тухай бүр | Тус газраас хувийн хэвшилтэй байгуулсан 3 гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх заалтыг тусган ажилласан. | Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээний тоо. | Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан байна. | - | Тайлант хугацаанд 12 байгууллагатай үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулж, дээрх гэрээнүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж ажилласан. Үүнд:<br>1.Нийслэлийн төр захиргааны автобаазтай “Автомашинаар үйлчлэх гэрээ”;<br>2.Райси прогресс ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ”;<br>3.Нийтлэг үйлчилгээний газартай “Байр ашиглалтын гэрээ”;<br>4.Нийслэлийн Мэдээлэл технологийн газар, Комтел ХХК-тай “Интернэт үйлчилгээний гэрээ”;<br>5.Санхүүгийн тооцоолох групп ХХК-тай “Программ хангамжийн лицензийн гэрээ”;<br>6.Х.Энхцэцэгтэй хийсэн “Засвар үйлчилгээний гэрээ”; |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7. Төрт ёс хаадын сан ХХК-тай “Чингис хааны иш хөрөнгө хийлгэх гэрээ”;<br>8.Нару групп ХХК-тай “Хэвлэх үйлчилгээний гэрээ”\;<br>9.”Коллпро ХХК-тай “Оператор үйлчилгээ үзүүлэх гэрээ”;<br>10.Иргэн Р.Хишигсүрэнтэй “Худалдах, худалдан авах гэрээ”;<br>11. Межик кроун ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ”;<br>12.Иргэн Н.Төмөрсүхтэй “Засвар үйлчилгээ хийх гэрээ”. |
| Зорилго 5: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | | | |
| 13 | 5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м) | Тухай бүр | Төрийн худалдан авах ажиллагааны газар болон Шүүхийн ерөнхий зөвлөл хамтран шүүхийн архивын зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн тухай мэдээллийг цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар дамжуулан тендерт оролцогч нарт мэдээлэл хүргүүлсэн.<br>Мөн тайлант хугацаанд “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох” журамд заасны дагуу 307 төсөл, арга хэмжээний үр дүнг цахим системээр дамжуулан тухайн тендерт оролцогчдод үр дүн | Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх. | Үйлчилгээ цахимжиж, ил тод байдал нэмэгдсэнээр авлигын эрсдэл буурсан байна. | - | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, үйлчилгээг цахимжуулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тус газраас зохион байгуулж буй худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр 100 хувь зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгосон өдөртөө багтаан Шалгарсан тендерт оролцогчийн материалын тухайн тендерт оролцогчдод ил болгон ажиллаж байна. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсаар дамжуулан төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөц, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажиллаж байна.<br>Албан хэрэг хөтлөлтийг 100 хувь цахим хэлбэрээр хөтөлж цаас, цаг хугацааг хэмнэн ажиллаж байна.<br>Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдаас “Ашиг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гарсан өдөрт багтаан ил болгож, тендерт оролцогчдын тендер шалгаруулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажилласан.<br>Тендерийн үнэлгээнд тендерт оролцогчдын борлуулалтын орлого, татварын өр, машин механизмын талаарх мэдээлэл, шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт зэргийг эрх бүхий байгууллагуудын<br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон лавлагааг ашиглан ажиллаж байна. | | | | сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг хянан хүлээн авч Шилэн дансны системд мэдээлж ажилласан.<br>Тус газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар байгуулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа ажлын хэсгээр хуралдаж, санамсаргүй сонголтын аргыг ашиглаж байна.<br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д холбогдсон эрх бүхий 9 байгууллагын лавлагаа, тодорхойлолтыг цахим системээс татан авч, тендер шалгаруулалтын үнэлгээнд ашиглаж байна.<br>Үүнд:<br>1. НДЕГ-аас "Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт";<br>2. УБЕГ-аас "Хуулийн этгээд бүртгэлтэй лавлагаа";<br>3. ТЕГ-аас "Татварын өртэй эсэх тодорхойлолт";<br>4. Сангийн яамны "Борлуулалтын хэмжээ, ашгийн тодорхойлолт";<br>5. ШШГЕГ-аас "Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй эсэх тодорхойлолт";<br>6. АТҮТ-өөс "Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа"; |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7. Эрх бүхий байгууллагаас "ААН-ийн тусгай зөвшөөрөлтэй эсэх мэдээлэл";<br>8. ШЕЗ-ийн тусгай архиваас "Иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан эсэх тодорхойлолт";<br>9. БШУЯ-аас "Боловсролын гэрчилгээний лавлагаа". |
| Зорилго 6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | | | | | | | |
| 14 | 6.1.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.26-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах; | Тухай бүр хуулийн хугацаанд | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, холбогдох мэдээллийг тухай бүр олон нийтэд ил тод мэдээлж ажилласан. | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжгэй байдлаар хүргэхэд анхаарсан байх. | Иргэд олон нийтийг мэдээллээр хангасан байна. | - | Шилэн дансны системд байршуулах мэдээллийг хугацааны хоцрогдолгүй, бүрэн гүйцэд мэдээлж шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлэн олон нийтэд ил тод мэдээлсэн. Үүнд:<br>1.Байгууллагын төсөв, санхүүгийн холбогдолтой жил, улирал, сарын хугацаанд байршуулах 17 төрлийн 95 мэдээлэл (төсөв гүйцэтгэлтэй холбоотой-43, Хөрөнгө оруулалт, тендер ХАА-тай холбоотой -11 Бусад төрлийн санхүүгийн холбогдолтой - 41 мэдээлэл)<br>2.Байгууллагын хүний нөөц, бүтэц орон тоотой холбоотой мэдээллийг 2021 оны 12 сараас 2022 оны 11 дүгээр саруудын 01-03-ны өдөр өөрчлөгдсөн байдлаар 12 удаа нийтэлсэн.<br>3.Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нараас 195 ширхэг "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг хянан хүлээн авч Шилэн дансны системд мэдээлж ажилласан.<br>4.Гэрээ байгуулагдсан 178 төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг маягтын дагуу хуулийн хугацаанд багтаан Шилэн дансны системд мэдээлж ажилласан. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1 сард-1 төсөл, арга хэмжээ,<br>2 сард-3 төсөл, арга хэмжээ,<br>3 сард-9 төсөл, арга хэмжээ,<br>4 сард -18 төсөл, арга хэмжээ,<br>5 сард - 60 төсөл, арга хэмжээ.<br>6 сард - 19 төсөл, арга хэмжээ<br>7 сард - 12 төсөл, арга хэмжээ,<br>8 сард - 3 төсөл, арга хэмжээ,<br>9 сард - 6 төсөл, арга хэмжээ,<br>10сард-14 төсөл, арга хэмжээ.<br>11сард-3 төсөл, арга хэмжээ.<br>2 сард-30 төсөл, арга хэмжээ.<br>Нийтийн мэдээллийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийн байгууллагын цахим хуудаст нийтэлсэн.<br><br>Үүнд:<br><br>✓ Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах ажлын мэдээ -5,<br>✓ Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах ажлын мэдээ – 2,<br>✓ Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах ажлын мэдээ-1,<br>✓ Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах ажлын мэдээ – 2, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ✓ Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөө,<br>✓ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын 2022 оны төлөвлөгөөг тус тус нийтэлсэн. |
| Тус газрын 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 6 зорилтын 14 арга хэмжээний хэрэгжилт “Бүрэн хэрэгжсэн” байна. | | | | | | | |

ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЦЭТГЭГЧ — Г.ЭНХТАЙВАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Ө.ОЮУНЧИМЭГ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН — С.ОЮУНЦЭЦЭГ